



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 157


Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн спортын IV наадмын сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 43 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтыг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн спортын IV наадмын сагсан бөмбөгийн тэмцээнийг 2015 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд “Буянт Ухаа” спорт ордонд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 2.202.000 /хоёр сая хоёр зуун хоёр мянган/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын спортын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээнийг урьдчилан бэлтгэлийг сайтар хангаж зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн С.Саранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны 09 дүгээр сарын 29 ны өдрийн
А/57 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Нийслэлийн иргэдийн спортын IV наадмын
наадмын сагсан бөмбөгийн
тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн
1.	Тамирчдын шагнал: 1-р байр 24хүн х 10.000 ₮ = 240.000 2-р байр 24 хүн х 8.000 ₮ = 192.000	432.000 төг
2.	Шүүгчдийн ажлын хөлс: /10 хүн х 2 өдөр х 20.000₮/	400.000 төг
3.	Анонс/цом 50.000₮	50.000 төг
4.	Медалийн үнэ:72 х 10.000 ₮	720.000 төг
5.	Диплом	100.000 төг
6.	Заал талбайн хөлс	500.000 төг
Дүн		2.202.000төг

Боловсруулсан:  С.Саранцэцэг
Хянасан: О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны ...*09*... дүгээр сарын ...*09*...ны өдрийн
A/57...дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Нийслэлийн иргэдийн спортын IV наадмын
Сагсан бөмбөгийн тэмцээний
шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|-----------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | С.Саранцэцэг |
| 2. Нарийн бичиг шүүгч | Д.Мягмарсүрэн |
| 3. Шүүгч | Г.Болд |
| 4. Шүүгч | Б.Цэрэндолгор |
| 5. Шүүгч | Б.Баясгалан |
| 6. Шүүгч | Ш.Мөнх-Эрдэнэ |
| 7. Шүүгч | С.Отгонбаатар |
| 8. Шүүгч | Б.Батсайхан |
| 9. Шүүгч | Б.Мөнх-Орших |
| 10. Шүүгч | Б.Батбаатар |